



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ .

2021 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/У/61

Номгон

“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих”  
хөтөлбөр боловсруулах ажлын  
хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/6 дугаар тогтоолын 2.2.2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Энхбаяр- Аймгийн Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч дарга

Гишүүд:

Б.Наранбаяр- Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Байгалмаа- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

В.Наранчимэг- Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Энхжаргал- Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Мэндбаяр- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

А.Ганболд- Нэгдсэн эмнэлгийн дарга


С.Үнэнбуян- Аймгийн эрчүүдийн холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: М.Дүгэрмаа- Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

2.Хөтөлбөрийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

601210066

3.Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН